

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2019.02.21

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР  
ҮЙЛЧЛЭХ ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ  
БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: Өлзийт сумын Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх хүнсний  
дэлгүүр сонгон шалгаруулах тендер [БХАӨСЗДТГ/201901007](#)

**2019 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь** сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баянхонгор аймгийн Өлзийт сумын Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах тендер: [БХАЭСЗДТГ/201901007](https://www.tender.gov.mn/lot/201901007)-ыг** нийлүүлэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 20,000 /хорин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[ 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 10 цаг 00 минут]**-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[ 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн [10 цаг 30 минут]**-д Засаг даргын Тамгын газрын 2 давхарт Санхүүгийн албаны өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[ Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газар  
(хоёр давхар, Санхүүгийн албаны өрөөнөөс авах буюу 88076100 утсаар  
холбогдоно.)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  3. Тендерийн иж бүрдэл
  4. Тогтмол үнэ
  5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Бэлтгэж ирүүлэх ТШӨХ-д заасан бусад материал;
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
  - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p><b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b></p>	<p align="center"><b>Шалгуур үзүүлэлт</b></p>
<p><b>ТӨӨЗ 1.1</b></p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу багц тус бүрээр гаргаж баталгаажуулсан үнийн санал ирүүлэх</li> <li>2. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх</li> <li>3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар /Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний дэлгүүрийн худалдаа эрхэлдэг байх/</li> <li>4. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх</li> <li>5. Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balanceаас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>6. Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх.</li> <li>7. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/</li> <li>8. Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолт ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>9. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /2018, 2017/ оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хуулбарыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан ebalance-аас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>10. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2018, 2017/ гэрээг хавсарган ирүүлэх.</li> <li>11. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018, 2017/ оны</li> </ol>

борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна.

12. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Гэрээг хавсарган ирүүлнэ. /Ижил төстэй ажил гэдэгт гэрээгээр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлагыг тооцно./
13. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Гэрээг хэрэгжүүлэх ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, агуулах склад, тээврийн хэрэгсэл зэргийг өөрийн болон түрээсээр эзэмшигч тухайгаа нотлох баримтаар ирүүлэх.
14. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй байх.
- 15.** Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/ гэрээг хавсарган ирүүлэх.
16. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Шаардлагатай. Гэрээт хугацаанд нийлүүлэгдэх бүх бараа нь эрүүл ахуйн ахуйн стандарт шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой, МХГ болон бусад холбогдох газрын шинжилгээний бичиг, тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн тохиолдолд буцаах зэрэг тодорхойлолтыг албан бичгээр ирүүлэх.
17. Тухайн тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, агуулах гэх мэт барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй, гэрээний дагуу нийлүүлэх боломжтойг нотлох баримт фото зураг зэрэг холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.
18. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Удирдах болон голлох ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэх нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар арын тушаалын хэсгийг оруулсан байх мөн Байгууллагын 2019 оны 01 дугаар сарын нийгмийн даатгалын НД-7,8 маягыг хавсарган ирүүлнэ.
19. 2018 онд хийсэн ижил төстэй ажлын гэрээний хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагаас тодорхойлолт авч ирүүлэх.
20. Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгөхөө албан бичгээр гаргаж

	<p>ирүүлнэ.</p> <p>21. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>22. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана.</p> <p>23. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>24. Тендерт оролцогч аж ахуй нэгж нь тендерийн баримт бичгийн дагуу материалаа эмх цэгцтэй, харагдахуйц тод бэлтгэж ирүүлнэ. /Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/</p> <p>25. Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн хөрөнгөөр</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: [Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.]  Огноо: <b>2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн</b> Цаг: <b>10 цаг 00 минут</b></p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг:  Давхар болон өрөөний дугаар: [ <b>Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газар (хоёр давхар Санхүүгийн албаны өрөө)</b> ]  Огноо: <b>2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн</b>  Цаг: [ <b>10 цаг 30 минут</b> ]</p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь [ <b>дараах багц</b>]-ээс бүрдэнэ:</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ  
ХҮНСНИЙ ТЕНДЕРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТИЙГ ОРУУЛАВ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ДАХ БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛД ТУХАЙН  
ҮЙЛДВЭРЛЭГЧ БОЛОН УЛСЫГ ЗААЖ ӨГСӨН НЬ ТҮҮНТЭЙ ДҮЙЦЭХҮЙЦ ГЭСЭН  
УТГА ИЛЭРХИЙЛЖ БАЙГАА БОЛНО.**

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Техникийн тодорхойлолтын хураангуй:

Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21 ны өдрийн А/32 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бүгдийг нь нийлүүлэх хүчин чадалтай байх 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд дараах хүнсний бүтээгдэхүүн хамаарна. Үүнд:

1. Мах дайвар бүтээгдэхүүн: Худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал амьтны мах, малын гэдэс дотор, толгой, шийр орно. /Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй/
2. Сүү сүүн бүтээгдэхүүн: Хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна.
3. Гурил гурилан бүтээгдэхүүн: /бялуу кекс орохгүй/
4. Төмс хүнсний ногоо /дарсан буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй
5. Будаа /Бүх төрлийн, үр тариа хамаарна/
6. Ургамалын тос
7. Өндөг
8. Жимс жимсгэнэ /Компод, жимсний хатаамал, хатаасан жимс хамаарахгүй/
9. Цөцгийн тос
10. Элсэн чихэр

**Нийлүүлэгдэх бараа нь дор дурдсан тодорхойлолт, стандартад нийцсэн байна.**

№	Хүнсний бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Тайлбар
1	Махан бүтээгдэхүүн	Хонины мах	Хадгалалтын горим алдагдаагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан шинэ мах
2		Ямааны мах	
3		Үхрийн мах	
4		Цувдай	
5		Адууны мах	
6	Сүүн бүтээгдэхүүн	Задгай сүү	Нутгийн чанарын шаардлага хангасан шинэ түүхий сүү ба тараг
7		Задгай тараг	
8		Савласан тараг	
9		Аарц	
10		Чихэртэй ааруул	
11		Өрөм	
12	Гурилан бүтээгдэхүүн	1-р гурил	Эх орны үйлдвэрийн хадгалалтын горим алдагдаагүй чанартай бүтээгдэхүүн
13		2-р гурил	
14		Гоймон	
15		Гурилан боов	
16		Талх	
17	Цөцгийн тос	Зөөхий	Нутгийн, чанарын шаардлага хангасан шинэ бүтээгдэхүүн
18		Масло	
19		Төмс	Нутгийн хөрсөнд ургасан чанарын шаардлага хангасан шинэ эрүүл хүнс
20		Байцаа	
21		Лууван	
22		Сонгино	



23	Хүнсний ногоо	Сармис	ш	Шинжилгээний бичигтэй хадгалалт хамгаалалтын горим алдагдаагүй чанартай бүтээгдэхүүн	
24		Чинжүү	кг		
25		Өргөст хэмх	кг		
26	Будаа	Цагаан будаа	кг		
27		Шар будаа	кг		
28		Хүүхдийн будаа	кг		
29		Гурвалжин будаа	кг		
30	Жимс жимсгэнэ	Алим	ш		Чанарын шаардлага хангасан Шинжилгээний бичигтэй хадгалалт хамгаалалтын горим алдагдаагүй чанартай бүтээгдэхүүн
31		Мандарин	ш		
32		Усан үзэм	кг		
33		чавга	кг		

### Дэлгүүрийн сонгон шалгаруулахад тавигдах шаардлага.

1. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдтэй харилцааны өндөр соёл, ёс зүйтэй, харилцах, баталгаат жингээр үйлчлэх, хугацаа дууссан, муудаж ялзарсан, үнэр орсон бүтээгдэхүүн худалдахгүй байх.
2. Бүтээгдэхүүний үнийг нийтэд харагдахаар ил тавих, хүнсний талоноор архи, согтууруулах ундаа, тамхи, ахуйн хэрэглээний бараа худалдахыг хориглоно.
3. Бараа бүтээгдэхүүний үнээ нэмж борлуулахгүй байх.
4. Нөөцийн мах болон дайвар бүтээгдэхүүнийг хүнсний бүтээгдэхүүн хадгалдаг агуулахад бэлэн байлгах. Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авч буй иргэдэд хүндрэл, хүлээлт үүсгэхгүй байх.
5. Е-баримт өгдөг байх.
  2. **Стандарт:** Тухайн барааны гарал үүсэл нь монгол улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
  3. **Баглаа, боодол:** Бараа баглаа боодол нь тухайн барааг зөөвөрлөх үед барааны ерөнхий чанар үзүүлэлтийг алдагдуулахгүй байна.
  4. **Бараа хүргэх газар:** Өлзийт сумын хүнсний эрхийн бичигт хамрагдах иргэд

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
Тендерийн нийт үнэ					

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ  
БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [0] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  3. Баталгаат засвар (ГЕН-5)
  4. Төлбөр (ГЕН – 7)
  5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup>
- 1.1. Нийлүүлэгдэх барааг захиалагч ЗДТГ-ын холбогдох ажилтан зарлагын баримт нэхэмжлэх, санхүүгийн баримтаар хүлээн авч баталгаажуулна.
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
    - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
    - 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
    - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
  - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
  - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[ 100 ]<sup>1</sup>** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
  - 9.1. Алданги оногдуулах хувь: **[0.5 хувь]**

Алдангийн нийт дүн: **[10 хувь]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч

шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

